



"Билэгт баялаг" ХХК

**"БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК-ИЙН ДАЛАН НҮҮРСНИЙ УУРХАЙН 2024
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

РД: 5294088, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV021008



ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

"БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ Э.ЭНХЗАЯА

БОЛОВСРУУЛСАН:

"БИЛЭГТ БАЯЛАГ" ХХК-ИЙН МЕНЕЖЕР Э.ЭНХТУЯА



Улаанбаатар хот

2023 он



АГУУЛГА.....	1
ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2 – 14
ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....	15 - 16
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	17
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18 - 23
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	24
ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27 - 31
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	31 - 33
УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ.....	35
2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ НИЙТ ТӨСӨВ.....	36
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....	37 - 43



ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн зорилго: "Билэгт Баялаг" ХХК-ийн MV-021008 тусгай зөвшөөрөл бүхий Далангийн нүүрсний уурхайн 2019 онд ЭБМЗ-ийн хэлэлцүүлэн тодотгосон үлдэгдэл нөөцөд тулгуурлан техник эдийн засгийн үндэслэл журамд нийцүүлэн уг төслийг холбогдох татвар төлбөрийг улс, орон нутгийн төсөвт төлөх, тодорхой тооны ажлын байрыг хадгалах, байгаль орчныг нөхөн сэргээхэд энэхүү төслийн зорилго оршино.

Төслийн нэр: "Далан нүүрсний уурхай" Ил аргаар ашиглах

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Дорноговь аймаг, Даланжаргалан, 3-р баг Олон овоо, Харуул овоо, 13-3 тоот, Улсын бүртгэлийн дугаар 9011506096, Регистрийн дугаар 5249088, Утас: 99999979

Төслийн байршил: "Билэгт баялаг" ХХК-ийн Далан нүүрсний уурхай төслийн тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны нэгжийн хуваариар Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, төмөр замын 25-р зөрлөг болон Улаанбаатар-Сайншандыг холбосон авто замаас 24 км, Даланжаргалан сумаас баруун хойш 28 км зайд байрлана.

Зам харилцаа: Уурхайн карьер, хөрсний овоолго, кемп, засварын газрууд нь хоорондоо шороон замаар холбогдсон. Уурхайгаас "МАК" ХХК-ийн сайжруулсан нүүрс тээврийн зам хүртэлх замын даланг уурхайн хөрс хуулалтаас гарсан хөрсөөр хийсэн ба технологийн тээврийн зам нь 20 м өргөнтэй нийт 1.4 км замын суурь нь 0.45 м зузаан, 0,25 метр хайрган хучилттай бөгөөд цаг агаарын байдалд тэсвэртэй, ус урсах боломжтой 100 хүртэл тонны даацтай тээврийн хэрэгслүүд явахад зориулагдсан.

Физик газарзүй: Уурхайн талбай нь намхан толгод зонхилсон тал хээрийн бүсэд багтах бөгөөд хамгийн өндөр цэг нь уурхайн талбайгаас зүүн хойш 3.7 км-т байрлах 1352.2 тоот өндөрлөг бол нам доор цэг нь уурхайн талбайгаас баруун тийш 7 км-т байрлах Бэхтийн-Улаан нуур /1179.6 м/ юм. Харьцангуй өндөржилт нь 50 м-с хэтрэхгүй.

Байгаль цаг уурын нөхцөл: Ордын талбайн орчин тойрон нь эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай. Даланжаргалан сум болон түүний орчин тойрны цаг уурын элементүүдийн сүүлийн 10 жилийн ажиглалтын дунджаар 16.5 мм хур тунадас унах бөгөөд үүний ихэнх нь 4-10-н сарын хооронд унана. 7-р сард дулааны дундаж хэм +25 градус, 01 сард -23 градус хүрч хүйтрэнэ. Дулааны улиралд +10 градусаас дээш хугацааны нийлбэр 2000-2800 градус, ургамал ургалтын үе нь 120-130 хоног байдаг. Жилийн туршид гол төлөв баруун зүгийн салхи зонхилох ба 4, 5 саруудад салхины хүч эрчимждэг.

Хөрсөн бүрхэвч: БОНБНУ-ний хүрээнд хийгдсэн хээрийн судалгааны үр дүнд тус төслийн талбай орчим нь хөрс газарзүйн мужлалтын хувьд Хангайн их мужийн өргөрөгийн бүсшилттэй нутгийн Цайвархүрэн хөрсний дэд бүсийн хүрээнд Баяндэлгэрийн хөрсний



тойрогт хамрагдаж байна. Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь хуурай хээр, говийн бүсийн зааг толгодорхог ландшафт зонхилсон бөгөөд толгодын хэсгээр сайргархаг цайвархүрэн хөрс, харьцангуй тэгшивтэр гадаргаар карбонаттай цайвархүрэн хөрс, хөндий хотгорын хэсгээр хужирлаг бараан, зузаан элсэнцэр цайвархүрэн хөрс тус тус тархсан.

Ургамлын аймаг: Төслийн талбай нь ургамлын мужлалаар Төв Азийн тал талархуу газрын ургамалжил бүхий Евразийн хээрийн их муж, хуурайдуу хэв шинжийн Алтанширээгийн тойрогт багтдаг ба газрын гадаргын хувьд цав толгод ухаа гүвээ, хотос хотгор, тойром бүхий гадарга зонхилох бөгөөд голлон тааралдах ургамлын хэв шинж нь бэсрэг уулсын налуу хажуу тал хөндийд крыловын хялгана-сөөгөнцөр, таана-сайрын хялгана, говийн хялгана-заримдаг сөөгөнцөр, дэрс бүхий таана-бударгана зэрэг цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилсон байх бөгөөд элсэрхэг сайргархаг тэгш талархаг талаар Зүүнгарын улаанбударгана, сэдэргэнэ, таана зэрэг цөл хээрийн ургамалжилттай.

Гадаргын болон гүний ус: Ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд хамаарах бөгөөд гидрогеологийн мужлалаар улирлын хомс тэжээлтэй мужид байрладаг. Энэхүү ай савд гол мөрний сүлжээ маш бага бөгөөд нэгж талбайд ноогдох голын нийлбэр урт нь 0.01 км/км. кв-аас доош байдаг. Даланжаргалан сумын нутаг нь " Умард Говийн Гүвээт-Халхын Дундад Тал" усны сав газарт хамаарах бөгөөд гадаргын ус бараг байхгүй ба унд ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх усыг ашигладаг. Сансрын болон геологи-техтоникийн зураг, усны эрэл хайгуулын судалгааны дүнгээс харахад тектоникийн хагаралын бүсэд оршдог. Нүүрсний үе, давхраасууд нь синклиналь тогтоцтой, харьцангуй бага гүнд байрлах ба 5-10 градусын уналтай ба геологи, тектоникийн тогтоц нь энгийн бүтцийг үүсгэнэ. Усжилт бүхий тектоникийн хагарал, ан цав багатай, тохрол, өргөгдөл, суултанд олон удаа орсон блок байхгүй байна. Ул суурийн хурдас нь уст үе, давхарга багатай шаварлаг хурдас тухайлбал хар, хар саарал өнгийн аргиллит, алевролит, алевро-элсэнчулуу, шаварлаг чулуулгаас тогтох ба усжилт бага байдаг онцлогтой. Ордын гидрогеологийн нөхцлийн хувьд дээрх хүчин зүйлүүд **ЭНГИЙН** нөхцөлтэй ангилалд оруулах боломжийг бүрдүүлж байна.

Амьтны аймаг: "Билэгт Баялаг" ХХК-ийн Зүүндалан, Далангийн төслийн ойр орчим говь, цөлийн амьтад голчлон тархсан ба ихэнх нь "Монгол орны 2 нутагтан, мөлхөгчдийн улаан данс-2006 он", "Монгол орны шувууны улаан данс-2011 он "Бүс нутгийн болон олон улсын үнэлгээний анхааралд өртхөөргүй /LC/ буюу өргөн тархац нутагтай элбэг гэсэн зүйл ангилалд орсон байна. Алагтолгой орчмын нүүрсний орд нь олон жилийн турш уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөний улмаас амьтны аймгийн төрөл зүйлээр ядмаг юм.




"Билэгт баялаг" ХХК

ДАЛАНГИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

Түүх соёлын дурсгалт газрууд: Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 2018 онд ШУА-ийн Палеонтологийн төвийн доктор Н.Ичинноровоор ахлуулсан баг судалгааны ажлыг хийсэн ба талбайд археологийн болон соёлын үнэт зүйл бүхий зүйлс илрээгүй байна.

Үржил шимт хөрсний овоолго: Шимт хөрсний хуулалтын ажил нь уурхай, овоолго, барилга байгууламж, зам талбай гэсэн үндсэн хэсгүүдээс хуулагдах бөгөөд нөхөн сэргээлтэнд ашиглагдах тул ойролцоох газарт байршуулна. Ашиглалтын жилүүдэд нийт 57.47 га талбайд шимт хөрс хуулалтын ажил гүйцэтгэх бөгөөд энэ нь 209.63 мян.м3 үржил шимт хөрс хуулж "Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS5916:2008" стандартыг баримтлан 5 метрээс илүүгүй өндөртэйгээр шимт хөрсний овоолго-1, шимт хөрсний овоолго-2-т хураан овоолно. Ил уурхайгаас хуулсан шимт хөрсийг одоогийн шимт хөрсний овоолго-1 буюу уурхайн зүүн урд буланд үргэлжлүүлэн байршуулна.

Гадаад овоолгын тэлэлтэд өртөх талбайн шимт хөрсийг овоолгын одоогийн шимт хөрсний талбай буюу хөрсний овоолгын баруун хойд талд, кемпийн урд талд нэмж байгуулна. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалтыг хуулах хөрсний үржил шимт үеийн агрохимийн шинж чанарын үзүүлэлтээс нь хамааруулан ялзмагийн агууламж 1% уусмалын орчинг тохируулан овоолгыг хийнэ. Шимт хөрсний овоолгыг хадгалах явцад салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу, барилгын болон бусад хаягдалд дарагдаж бохирдохооссхамгаалах, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж хэлбэршүүлэн ургамалжуулж хадгална.



Далан нүүрсний уурхайн газарзүйн байршил


Уурхайн одоогийн байдал: “Билэгт Баялаг” ХХК-ийн Далангийн нүүрсний уурхайн нөөцийг 2020.04.01-ний байдлаар баттай (А) зэрэглэлийн 2,076.69 мян.тн, бодитой (В) зэрэглэлийн 2,582.49 мян.тн, боломжтой (С) зэрэглэлийн 1,309.91 мян.тн, нийт баттай, бодитой болон боломжтой (А+В+С) зэрэглэлээр 5,969.10 мян.тн, агуулахын үлдэгдэл



бодитой (В) зэрэглэлээр 155.49 мян.тн нүүрс, нийт газрын хэвлий дэр болон агуулах дахь цэвэр нүүрсийг 6,124.59 мян.тн нөөцтэйгээр ЭБМЗ-д батлуулсан байдаг. Уурхайлалтын ажлыг гэрээт туслан гүйцэтгэгчийн тусламжтайгаар хийж байна. Өмнөх 2016 онд ЭБМЗ-өөр баталж байсан ТЭЗҮ нь тусгай зөвшөөрлийн MV-014492 дугаар бүхий "Фриендшип Ресурсис" ХХК-ийн лицензийн талбайтай нэгтгэсэн байх үед жилийн 500 мян.тн олборлох хүчин чадалтайгаар хийгдсэн байдаг. 2018 онд уурхай нээгдсэнээс өнөөг хүртэл ордын нүүрсний тогтцыг судалж үнэлэх, нүүрсний дундаж чанарын хэмжээг тогтоох, зах зээл, хэрэглэгчийн шаардлага, ордод нийцсэн олборлолтын арга, технологийг тогтоож хэвшүүлэх ажлууд шат дараалан тасралтгүй хийгдэж байна.

Далангийн нүүрсний уурхай нь Алагтогоогийн ордод үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудаас хэрэглэгчдийн нүүрсний чанарын шаардлагыг найдвартай, тогтмол жигд хангаж байгаа цөөхөн уурхайн нэг юм.

Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ 178.98 га, үүний 133.68 га талбай нь нүүрсжилт тогтоогдсон тул хөрс болон нүүрсний овоолго, кемпийн зай талбай хумигдмал ба энэ байдал нь талбай ашиглалтыг дээд зэргээр хангах, хөрсний дотоод овоолгыг даруй эхлүүлэх үндсэн чиглэлийг баримталж ажиллахыг шаардана.




Далан нүүрсний уурхайн агаарын зураг

Уурхайн ирээдүйн хэтийн төлөвлөгөө: Нүүрсний эрэлт хэрэгцээ ихсэхтэй холбоотойгоор нүүрсний үнэ өсөх, олборлолтын зардал буурах зэрэг ордын нөөцийг бүрэн ашиглах боломж гарч болох бөгөөд одоо хийж байгаа уурхайн ахилтын чиглэл, уурхайн гадаад, дотоод овоолгын зохион байгуулалт нь ирээдүйд олборлолтын ажил үргэлжлүүлэн хийх уул техник талаасаа боломжтой байх нь чухал юм.

Иймээс уурхайн хүрээг үнэ 2 дахин өсөх Виттл Шелийн 74-р уурхайн хүрээтэй давхцуулж ирээдүйд үүсэж болох эрсдлийг тооцож төлөвлөлтийг уялдаатай хийх шаардлагатай юм. 74-р уурхайн хүрээнд орох нөөц нь А, В зэрэглэлээр 5,472.479 мян.тн буюу нийт үлдэгдэл геологийн А, В зэрэглэлийн нөөцийн 95%-ийг олборлохоор байна.



Иймээс гадаад, дотоод овоолгыг хэлбэршүүлэхдээ 74-р уурхайн хүрээтэй давхцуулж, уурхайн эцсийн дизайныг үүсгэсэн.



Хэтийн уурхайн хүрээ хязгаар

Геологийн тогтоц: Алагтоогогийн чулуун нүүрсний ордыг агуулж буй грабен хэлбэрийн хотос структур нь хожуу мезозойн ревивацийн нөлөөллөөр үүссэн бөгөөд говийн атриат бүсэд хамаарагдана. Энд дээд юра-доод цэрдийн Цагаанцав формацийн бялхмал-тунамал хурдас, доод цэрдийн туфоген-тунамал хурдас, дөрөвдөгчийн эх газрын тунамал хурдас тархсан байдаг.

Геологийн нөөц: Виттл Шелийн хүрээний дагуу уурхайн эцсийн дизайныг загварчилсан бөгөөд лицензийн хүрээний дагуу урд, хойд жигүүрийн нүүрсийг бүрэн олборлох уулын ажил нь лицензийн хүрээнээс гарах учраас уурхайн дизайныг лицензийн хүрээнээс гаргах боломжтой гэж үзээд бүх нөөцийг гүйцэд олборлохоор төлөвлөсөн. Нийт уурхайн эцсийн дизайнаар чулууны үетэйгээр 5,278.604 мян.тн А, В зэрэглэлийн, хам олборлогдох С зэрэглэлийн нөөц олборлож 15,399.809 мян.м³ хөрс хуулахад хөрс хуулалтын дундаж коэффициент 2.91 м³/тн байна. Цэвэр нүүрсний хэмжээгээр тооцвол нийт 4,175.979 мян.тн буюу А зэрэглэлийн 1,701.748 мян.тн, В зэрэглэлийн 2,211.612 мян.тн, С зэрэглэлийн 262.618 мян.тн нүүрс олборлохоор байна.

Үйлдвэрлэлийн нөөц: Ашиглалтын үеийн хаягдал бохирдлын дараах байдлаар уурхайгаас олборлон борлуулах нүүрсний хэмжээ нь 3,939.330 мян.тн байхаар байна. 1-р давхаргаас 170.715 мян.тн, 2-р давхаргаас 2,379.635 мян.тн, 3-р давхаргаас 1388.981 мян.тн нүүрсийг тус тус олборлон борлуулна. Ил уурхайн нийт уулын цулын хэмжээ 19,177.830 мян.м³, үүнээс хөрс хуулалтын хэмжээ 15,399.809 мян.м³, нүүрсний давхаргаас гарах бохирдуулагч үе болон хаягдал нүүрсний хэмжээ 565.72 мян.м³ болж нийт хөрс хуулалтын ажлын хэмжээ 16,147.57 мян.м³ байхаар байна.



Уурхайн хүчин чадал: Өмнөх ТЭЗҮ-ээр уурхайн хүчин чадал 500 мян.тн/жил байсан. 2019-2020 оны хооронд уурхай төслийн хүчин чадлаа бүрэн эзэмшиж сард 50 мян.тн нүүрс буюу жилд 600 мян.тн/жил нүүрс олборлон борлуулах боломжтой болсон. Борлуулалтын хэмжээнд нөлөөлж буй хүчин зүйл нь Замын-Үүд боомтын нэвтрүүлэх чадал, төмөр замын тээвэр вагоны хүрэлцээ хангамжгүй байдал төслийн хүчин чадлыг 1 сая.тн хүргэж нэмэгдүүлэхэд бэрхшээл болж байна.

Алагтогоогийн бүлэг нүүрсний ордод үйл ажиллаж явуулж байгаа уурхайнуудаас “Фриендшип ресурсис” ХХК-ийн Далангийн нүүрсний уурхай нь бусад уурхайнуудтай харьцуулахад нүүрсний чанарын тогтвортой байдал, нийлүүлэлтийн тасралтгүй байдлаараа ялгардаг. Уурхайн жилийн хүчин чадлыг төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс гаргасан бизнес төлөвлөгөөний дагуу жилд 600 мян.тн нүүрсийг олборлон борлуулна гэж тооцсон байна.

Ил уурхайн тоног төхөөрөмжийн иж бүрдэл: Автотээвэртэй гадаад болон дотоод овоолготой ил уурхайн ашиглалтын системийн үндсэн тоног төхөөрөмж болох өрмийн машин, ухаж ачих тоног төхөөрөмж болон автотээврийн тоног төхөөрөмжийн сонголтыг хийж гүйцэтгэлээ. Уурхайн хэвийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн сонголтыг гүйцэтгэх ажлын хэмжээ, цар хүрээнд үндэслэн тохирох техникүүдийг сонгож ТЭЗҮ-д тусгасан.

Үзүүлэлт	Doosan-DX700
Утгуурын багтаамж, м ³	4.5
Хөдөлгүүрийн чадал, кВт	345
Нийт жин, кг	70000
Гарны урт, м	8.4
Мах хурд км/цаг	5.2
Жилийн бүтээл, м ³	1180000



Үзүүлэлт	CAT-325DL
Утгуурын багтаамж, м ³	1.6
Хөдөлгүүрийн чадал, кВт	103
Нийт жин, кг	35100
Гарны урт, м	3.2
Мах хурд км/цаг	5.5
Жилийн бүтээл, м ³	275000





"Билэгт баялаг" ХХК

ДАЛАНГИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

Үзүүлэлт	Shacman
Даац, тн	70
Хөдөлгүүрийн чадал	426 м.х
Нийт жин, тн	25
Тэвшний багтаамж, м ³	65
Хурд км/цаг	75
Жилийн бүтээл, м ³	95660



Үзүүлэлт	Howo-371
Даац, тн	70
Хөдөлгүүрийн чадал	371 hp
Мах хурд км/цаг	70
Жилийн бүтээл, м ³	400000



Үзүүлэлт	Nordbenz
Даац, тн	25
Хөдөлгүүрийн чадал	371 м.х
Нийт жин, тн	13.7
Тэвшний багтаамж, м ³	18.2
Хурд, км/цаг	70
Жилийн бүтээл, м ³	160000



Үзүүлэлт	Sunward SWDE120
Өрмийн машины тэнхлэгийн даралт	140
Хөдөлгүүрийн чадал	254 кв
Түлш зарцуулалт	40 л/цаг
Өрмийн хошууны диаметр	0.12 м
Өрөмдөх гүн	24 м
Өрмийн хошууны эргэлтийн давтамж	2.86 эрг/сек
Штангны урт	4 м
Жилийн бүтээл	152796.65





"Билэгт баялаг" ХХК

ДАЛАНГИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

Үзүүлэлт	SEM-822
Хутганы багтаамж	6.4 м ³
Хутганы урт	4617 мм
Хутганы өндөр	1511 мм
Явах ангийн өргөн	2620 мм
Хамгийн их хутганы зоогдох гүн	540 мм
Сийрүүлэгчийн хамгийн их зоогдох гүн	655 мм
Ажлын жин	24600 кг
Хөдөлгүүрийн хүчин чадал	162 кВт



Үзүүлэлт	SDLG G9190
Хөдөлгүүрийн чадал	146 кВт
Хөдөлгөөний давших дээд хурд	5.4-38 км/цаг
Хөдөлгөөний ухрах дээд хурд	5.4-24
Эргэлтийн радиус	7.8 м
Ухах хамгийн их гүн	500 мм
Хусуурын хамгийн их эргэлтийн өнцөг	20 градус
Хусуурын өргөн	3.96 м
Жин	15.8 тн



Замын тоос дарах ажиллагаа: Орон нутгийн уур амьсгал, замын хөдөлгөөний эрчим, тухайн замын тоосжилтын байдлаас хамааран замын тоос дарах ажлыг 4-10 сар буюу дулааны улиралд ээлжинд 4 удаа явуулна. 11-3-р сард буюу өвлийн улирал замыг грейдерээр хусаж цэвэрлэнэ. Усны машин нь тодорхой чиглэлийн дагуу явж замын тоос дарж ус шүршинэ. Шаардлагатай тохиолдолд замыг хэсэгчлэн тоос дарах ажиллагааг хэрэгжүүлнэ. Замын тоос дарах ажиллагаанд 25 тн багтаамжтай БНХАУ-д үйлдвэрлэсэн усны машин ашиглана





Нүүрс бутлах үйл ажиллагаа: Далангийн нүүрсний уурхайн ТЭЗҮ-д тусгагдсанаар жилийн 600 мян.тн нүүрс олборлох ба үүний 75% орчмыг бутлах шаардлагатай буюу сард бутлах шаардлагатай нүүрсний хэмжээ 47 мян.тн, хоногт бутлах шаардлагатай нүүрсний хамгийн хэмжээ 1400 тн байна. Ачаалал ихтэй үе гарч болзошгүй учраас 2 бутлуур сонгож нүүрс олборлолтын ажил багатай өдөр нэг бутлуурыг зогсоож нөөцөд байлгана. Хэрэв аль нэг бутлуурт эвдрэл гэмтэл гарч, засвар үйлчилгээний ажил хийж зогсвол нөгөө бутлуур нь дангаараа нүүрс бутлах ажлыг зогсоохгүй ажиллах чадалтай байна.

"Билэгт Баялаг" ХХК-ийн одоо ашиглаж байгаа нүүрсний талбай байрлах зөөврийн дизель, цахилгаан хосолсон НК6126 бутлуур нь цагт 170 тн/цаг хүчин чадалтай бөгөөд хоногт 1 ээлжээр 11 цаг ажиллахад 1870 тн нүүрс бутлаж хүчин чадалтай учраас дээрх бутлуурыг ашиглалтын хугацаанд нөөцөд 1ш нэмж авахаар тооцсон байна.



Уурхайн барилга байгууламж: Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн удирдлага, инженерийн баг, нүүрсний борлуулалт, гадаад тээвэрлэлтийн ажлыг хариуцаж ажиллана. Уулын бүхий л ажлыг гэрээт туслан гүйцэтгэгчдээр хийгддэг. Уурхайн үндсэн болон туслан гүйцэтгэгчийн кемпүүд нь биеэ даасан цогцолбор байдлаар байгуулагдсан. Одоогийн уурхайн хэрэгцээнд ашиглагдаж буй захиргаа, засвар үйлчилгээ болон бусад туслах барилга байгууламжуудтай бөгөөд шаардлагатай хэрэгцээг хангахуйцаар уурхайн талбайн цогцолбор барьж байгуулагдсан гэж ойлгож болно. Туслан гүйцэтгэгчийн кемп-д уурхайн өдөр тутмын ажлын наряд-аюулгүй ажиллагаа зааварчилгааны хэсэг, захиргаа гэх мэт бүх хэлтсийн ажлын байрыг тус бүрт нь байгуулан ажиллаж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн хөрөнгөөр 80 хүн амьдарч ажиллах бүхий кемпийг тусгай зөвшөөрлийн талбайн баруун талд барьж байгуулсан. Туслан гүйцэтгэгчид нь үндсэн кемпд хамт байрлах бөгөөд удирдлага, уурхайн ИТА нар нь тусдаа 4 ш тусгайлан тохижуулсан контенерт кемпийн хойд хэсэгт байрлах бөгөөд үүнд 16 хүний багтаамжтай.



Ажилчдын кемп

Засвар үйлчилгээний төв: 2023 онд шинээр засвар үйлчилгээний төв барьж ашиглалтанд оруулсан. Уг засварын байр нь автосамосвалууд болон хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээг хийх, тос тосолгооны материал хадгалахаар зориулагдсан.



Засварын байр

Шатах тослох материалын агуулах: ШТС-ын түр агуулах нь уурхайн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөхгүй газарт байрласан байх шаардлагатай ба одоогийн нөхцөлд засварын төв талбайн зүүн талд тугайлан зориулж тоногдсон 20 тн багтаамж бүхий 1ш юмкост, 2 түгээгүүр ашиглаж байна. Төслийн хугацаанд энэ байрлалд нь ашиглахаар төлөвлөсөн бөгөөд жил тутам баталгаажуулж, аюулгүй байх, байгаль орчинд хор хөнөөлгүй байх тал дээр тусгайлан анхаарч ажиллахаар төлөвлөсөн.



ШТС

Цахилгаан хангамж: Уурхай 2017 онд Даланжаргалан сумын Элдэв баг нүүрс олборлох уурхайн 10кВ-ын ЦДАШ, 250 кВА чадалтай 10/0.4 кВ-ын трансформатор бүхий АТП маягийн агаарын дэд өртөөнд холбогдсон.

Усны хэрэглээ: Уурхайн усны хэрэглээ нь ахуйн болон ундны ус, технологийн тоос дарах ус, ус шавхайн зайлуулах гэсэн хэсгээс бүрдэнэ. Унд ахуйн усыг кемпээс зүүн тийш 150 метрт байх гүний худгаас хангадаг.

Уурхайн карьерт хуримтлагдсан усыг шавхан зайлуулахад гарсан усны зарим хэсгээр уурхайн тоос дарах технологийн усны хэрэглээг хангана.



Гүний худаг



Уурхайн ажиллах хүчин чадал, хүний нөөц: Ил уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэснээр шууд ажлын байраар нийт 179 хүнийг хангана. Захиргааны хэсэгт нийт 30, ил уурхайн болон бутлах хэсэгт 98, бусад хэсэгт 52 тус тус ажиллаж байна. Нийт ажилчдын 23 ажилтан нь төсөл хэрэгжүүлэгч компаний ажилтнууд байх ба бусад ажилчид нь туслан гүйцэтгэх компанийн ажилчид байна.

Ашиглаж байгаа хүдгийн мэдээлэл

Байршил	Худгийн нэр	Уурхайгаас байрлах зай	Худгийн гүн/ л.с	Зориулалт
Дорноговь, Даланжаргалан, Элдэв баг, Далан уурхай	Цооног 0603-18189	Уурхайн кемпийн хажууд	56 м/0.33	Унд, ахуй

Далангийн нүүрсний уурхайн 2024 оны төлөвлөгөө

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Жилийн төлөвлөгөө	1-р улирал				2-р улирал				3-р улирал				4-р улирал			
			1	2	3	Дүн	4	5	6	Дүн	7	8	9	Дүн	10	11	12	Дүн
Хөрс хуулалт	мян.м ³	2100.2	175	175	175	525.01	175	175	175	525.01	175	175	175	525.01	175	175	175	525.01
Нүүрс олборлолт	мян. тн	540.01	45	45	45	135.01	45	45	45	135.01	45	45	45	135.01	45	45	45	135.01
	мян.м ³	392,150	33.5	33.5	33.5	100.74	33.5	33.5	33.5	100.74	33.5	33.5	33.5	100.74	33.5	33.5	33.5	100.74
Нүүрс борлуулалт	мян. тн	540.01	45	45	45	135.01	45	45	45	135.01	45	45	45	135.01	45	45	45	135.01

2023 оны үйл ажиллагааны эдийн засгийн үзүүлэлт: Энэ онд 271.400 тн нүүрс олборлон 225.400 тн нүүрс борлуулж улс болон орон нутгийн төсөвт татвар, хураамж хэлбэрээр 2.995.277.435 төгрөг төвлөрүүлсэн байна.

**ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ**

Эх сурвалж: БОНБНУ-ний нэмэлт тодотгоол 2022

№	Байгаль орчны асуудлууд	Нөлөөллийн үр дагавар			
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их
Төсөл хэрэгжих үеийн гол ба болзошгүй нөлөөлөл					
Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудлууд					
1	Уурхайн газар ашиглалттай холбоотой нийгэм эдийн засгийн нөлөөлөл				+
2	Уурхайн газар ашиглалттай холбоотой экологийн нөлөөлөл				+
3	Уурхайн бусад байгууламжийн байршилтай холбоотой нөлөөлөл			+	
4	Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	+			
Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл					
5	Ургамлан нөмрөг устгах, байгалийн аясаар ургах чадвар доройтох				+
6	Орчны ургамлан нөмрөг доройтох, хөл гézрын ургамлаар солигдох			+	
Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл					
7	Худгийн ус бохирдох		+		
8	Гүний усны горим өөрчлөгдөх		+		
9	Хөрсний усны түвшин буурах		+		
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл					
10	Хөрсний үржил шимт чанар алдагдах				+
11	Газрын гадаргуугийн ландшафтын өөрчлөлт				+
12	Ухаш үүсэх				+
13	Овоолгууд бий болох				+
14	Хөрсний бохирдол үүсэх			+	
Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл					
15	Амьтдын амьдрах орчин хомсдох				+
16	Идэш тэжээлийн орчин хомсдох			+	
17	Аюултай орчин буй болох/ухаш үүсэх зэргээр/			+	
Орчны агаарт үзүүлэх нөлөөлөл					



18	Агаар дахь тоос тоосонцорын хэмжээ ихсэх				+
19	Дуу чимээ, шуугиан				+
20	Хорт хий, утаа				+
Бусад нөлөөлөл					
21	Осол аваар, хортой нөхцөл үүсэх, халварт өвчин гарах эрсдэл		+		
22	Экологийн дотоод хяналтын асуудал				+
23	Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг гарздах				+
24	Төсөл нь уурхай орчимд суурьшил бий болгох эсэх	+			
25	Төсөл нь орон нутгийн ажилгүйдлийг бууруулах, өрхийн орлого нэмэгдэхэд нөлөөлөх эсэх			+	
26	Төсөл нь тухайн бүс нутгийн нийгэм, эдийн засагт нөлөөлөх			+	
	Нөлөөллийн үнэлгээний тоон утгын нийлбэр	6	5	9	11
	Нөлөөллийн үнэлгээний тоон утгын хувь	20	13.4	30	36.6

Энэхүү төслийн байршил, техник технологийн шийдэл болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх болзошгүй нөлөөллийн дүнгээс үзэхэд 20.0 хувь нь нөлөөлөлгүй, 16.7 хувь нь бага, 30.0 хувь нь дунд, 36.6 хувь нь их нөлөөлөл үзүүлэхээр байна.

Дунд нөлөөллийн 30.0 хувьд төсөл нь орон нутгийн ажилгүйдлийг бууруулах, өрхийн орлого нэмэгдэх зэрэг 6.7 хувь нь эерэг нөлөөлөл байгаа бол их нөлөөллийн 3.3 хувь нь эерэг нөлөөлөл байна.

Байгаль орчинд үзүүлэх их нөлөөллийн 33.3 хувь нь сөрөг нөлөөлөл байна. Тухайн төслөөс хүрээлэн буй орчинд 80 орчим хувь нь ямар нэг хэмжээгээр сөргөөр нөлөөлж байгаа учир энэхүү тайланд тусгасан байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд заасан арга хэмжээг цаг тухайд нь чанартай гүйцэтгэх шаардлагатай.



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Энэхүү төлөвлөгөөний гол зорилт нь байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах.

БОНБУ-ний сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах талаарх заалтуудыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг бодит байдал дээр турших.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгахыг зорих бөгөөд БОНБНҮнэлгээ, Байгаль орчны аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, авах арга хэмжээнүүдийг жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллах нь гол зорилт юм.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар	Нүүрсний агуулахын овоолгуудад уугилт үүссэн үед тухай бүр зогсоох	Нүүрсний агуулах	удаа	Тухай бүр өөр гарна.	Уугилт үүссэн үед	Тухай бүрт өөр гарна.	Уугилт үүссэн үед	БО-ыг хамгаалах тухай хууль
		Уурхайгаас нүүрс тээврийн нэгдсэн зам хүртэлх зам, доторх замууд, нүүрсний овоолгуудад хуурайшилт мөн салхи ихтэй үед усалгаа хийх	Далан нүүрсний уурхай	удаа	50.000	Тоос ихтэй үед	Тухай бүрт өөр гарна.	Тоос ихтэй үед	ХАБЭА-н тухай хууль, БО-ыг хамгаалах тухай хууль



ДАЛАНГИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

		Уурхайгаас нүүрс тээврийн нэгдсэн зам хүртэлх зам, доторх замуудын суларсан шороог хусч тэгшилж тоосжилтыг багасгах	Далан нүүрсний уурхайн доторх замууд, нүүрс тээврийн нэгдсэн зам хүртэлх зам	-	-	-	Уурхайн уулын ажлын зардлаас гарна.	Тухай бүр өөр гарна.	ХАБЭА-н тухай хууль, БО-ыг хамгаалах тухай хууль
2.	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Карьерын ус шавхан зайлуулах насос дээр суурилуулсан тоолуур, унд ахуйн ус дамжуулах шугам сүлжээ тоолуурт эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд шуурхай засах	Далан нүүрсний уурхай	ш	Тухай бүр өөр гарна.	Эвдрэл гэмтэл гарсан үед	Тухай бүр өөр гарна.	Эвдрэл гэмтэл гарсан үед	MNS0900:2018. Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ



ДАЛАНГИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

		Ундны хэрэглээний усны шугам дээр ус цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах	Кемпийн гал тогоо	ш	200.000	1	200,000	Жилд 1 удаа	Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018
		Карьерын ус шавхан зайлуулах насос дээр тоолуур суурилуулж баталгаажуулах	Далан нүүрсний уурхай	ш	450.000	1	450.000	1-р улиралд	Усны тухай МУ-ын хууль
		Ус ашиглалтын мэдээг сар бүр төрөл тус бүрээр бүртгэнэ.	Далан нүүрсний уурхай	бүртгэл	-	-	-	Сар бүр	УГГХДТСГЗахирааны ус ашиглуулах дүгнэлт, Ус ашиглах гэрээ
		Худгийн болон ус шавхан зайлуулах насосын тоолуурын заалтыг сар бүр сумын байгаль орчны байцаагчаар баталгаажуулан акт үйлдэх	Ус шавхан зайлуулах насос, унд ахуйд ашигладаг худаг	ш	20.000	12	240.000	Жилийн турш	Ус ашиглах гэрээ



ДАЛАНГИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

3.	Хөрсөн бүрхэвч	Хөрс бохирдсон тохиолдолд цэвэрлэн бохирдсон хөрсийг цементэн хучилттай талбайд хадгалах	Далан нүүрсний уурхай	удаа	5000	10	50.000	Бохирдсон тохиолдолд	Хог хаягдлын тухай хууль, БОНБНҮн элгээ
		Далан нүүрсний уурхайн ахуйн хаягдал усны хэмжээнд тохирох бага оврын цэвэршүүлэх байгууламжуудын технологи, үнийн судалгаа хийх	Далан нүүрсний уурхай	удаа	-	1	-	2-р улиралд багтаан хийнэ.	Хүрээлэн буй орчин, усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS4943:2015 стандарт
		Нүхэн жорлон, угаадасны нүхийг стандартад нийцүүлэх	Далан нүүрсний уурхай	ш	200.000	1	200.000	2, 3-р улиралд	Нүхэн жорлон, угаадасны нүх, ерөнхий шаардлага MNS5924:2015 стандарт
		Нүхэн жорлон болон ахуйн бохир ус цуглуулах саванд ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Далан нүүрсний уурхай	ш	50.000	2	100.000	Жилд 2 удаа	Нүхэн жорлон, угаадасны нүх, ерөнхий шаардлага MNS5924:2015 стандарт



ДАЛАНГИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

		Шинээр хөрс хуулалт, барилга байгууламж барих, зам талбай засах зэрэг ажлын үед шимт хөрсийг хуулж биологийн нөхөн сэргээлтэнд зориулж хадгалах	Далан нүүрсний уурхай	М ³	Уурхайн уулын ажлын зардлаас гарна.	20.000	Уурхайн үйл ажиллагааны зардлаас гарна.	Шинээр хөрс хуулалт, барилга байгууламж барих, зам талбай засах ажлын өмнө	Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008 стандарт
		2024 онд шинээр мод тарих	Далан нүүрсний уурхай	ш	15.000	200	3.000.000	5, 6-р саруудад	1 тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн
		Машин механизм зогсох талбайг цементлэх	Далан нүүрсний уурхай	М ²	10,000	100	1,000,000	2-р улиралд	БО-ыг хамгаалах хууль, улсын байцаагчийн албан шаардлага
		Хаягдал тос тосолгооны материал түр хадгалах цэгт хальж урсахаас сэргийлж хөмсөг хийх	Далан нүүрсний уурхай	м	2000	50	100,000	2-р улиралд	БО-ыг хамгаалах хууль, улсын байцаагчийн албан шаардлага



"Билэгт баялаг" ХХК

ДАЛАНГИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

4.	Ургамлан нөмрөг	Технологийн замын трасс дагуу явж байгаа эсэхэд тээврийн гэрээт компанийн жолооч нарт хяналт тавьж зөрчил үүсэхээс сэргийлэх	Нүүрс тээврийн зам	км	-	-	-	Жилийн турш	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
